

ОРЧУУЛГЫН ЭХИЙГ АРИУТГАН ШҮҮЖ, ЗАСАН НАЙРУУЛЖ БАЙСАН УЛАМЖЛАЛААС

Д.Бүрнээ⁹⁷

Товч утга: Монголчууд бурханы шашин номын орчуулгын төвөд эх судрыг шүүн ариутгаж байсан түүхтэй. Үүний нэг тодорхой жишээ бол буддын утга зохиолын их цоморлиг болох төвөд Ганжуурын Нартан барын алдаа мадгийг засаж байсан уламжлал юм. Энэ нь төвөд Ганжуурыг зөв уншиж судлах төдийгүй орчуулахад чухал үүрэгтэй байв. Түүнчлэн монгол шунхан барын Ганжуурын орчуулгыг журамлах зорилгоор хятад барын төвөд Ганжуурын эхийг үндэс болгож найруулгыг засаж байсан болон монгол орчуулгын түүхэнд энэ уламжлалыг иргэний чиглэлийн зохиолд ч баримталж байсан уламжлалаас энд өгүүлнэ.

Түлхүүр үг: эх судрыг ариутган шүүх, эхийг судлах, орчуулгын алдааг засах, орчуулгын найруулгыг өөрчлөх

Орчуулгын ажил эх зохиолыг судлахаас эхлэх учир эн тэргүүн төвөд судрын олон зүйл бар хэвлэл, гар бичмэл эхийг бүртгэж, зөв эхийг олж тогтоохыг монголчууд чухалчилж байжээ. Тухайлбал, монгол Ганжуурын эх болох төвөд Ганжуурын зарим хэвлэлийн алдааг шүүн нягталж байсан талаар акад. Ц.Дамдинсүрэн бичсэн байна. Түүний өгүүлснээр төвөд Ганжуурын олон зүйл бар хэвлэл болох Нартан, Дэргэ, Жонэ, Лхас, Хүрээ, Бээжин зэрэг бар хэвлэлээс анхны бар болох Нартан барын Ганжуурыг монголчууд эх сурвалж болгон авч үзэж, заан сургаж уламжилж байсан учраас эх бичвэрийг нь ихэд анхааран судалж иржээ. Төвөд Ганжуурын Нартан барын эхийг бусад бар хэвлэлтэй зэрэгцүүлэн тулгаж, хянан нягталж байсан 19 дүгээр зууны эрдэмтэд болох Цахар гэвш цорж Лувсандаш, Сэрдог хутагт Лувсанчүлтэмжамц, Их Хүрээний гавж Дамдинсүрэн, Жамсранжав, Шадавдандар зэрэг мэргэдийн дундаас хамгийн том ариутгал буюу засвар хийсэн хүн бол Түшээт хан аймгийн Дайчин вангийн хошууны Шадавдандар буюу Дандар аграмба ажээ. Тэр бээр Ганжуурын 100 гаруй ботиос Нартан болон хятад шунхан барын төвөд Ганжуурын 70 орчим ботийн алдаа мадгийг шүүн нягталсан байна. Дэргэ барын Ганжуурыг үндэс болгож засахдаа үг нэмэгдсэн, орхигдсон, гээгдсэн, тасарсан, солигдсон зэрэг мадгийг олж тогтоож шүүн ариутгажээ. Ийнхүү засахдаа “Жалзэ тэмбан” хэмээх бичмэл төвөд Ганжуур болон төвөд Данжуурын холбогдох үндсэн судар тэргүүтнийг ашиглажээ. Төвөд эх судрыг ариутган шүүж байсан энэ уламжлалыг 20 зууны дундад үед Гандан хийдийн хамба лам агсан С.Гомбожав тэргүүтэй судлаачид үргэлжлүүлэн, Дандар аграмбын ариутган шүүсэн боловч үрэгдэж гээгдсэн Винайн судрын хэсгийг Данзан-Одсэр болон бусад хүмүүсийг удирдан нөхөн гүйцээлгэсэн байна. Ийнхүү төвөд эх судрыг

⁹⁷ МУИС, ШУС, ХУС-ын МХХШТ-ийн профессор, доктор

ариутган шүүж, түүнийг үнэн зөв унших төдийгүй орчуулахыг эрхэмлэн дээдэлж байсан билээ.

Монголчууд шашин номоо хүндлэн дээдэлж, бурханы зарлиг сургаал бол хүний нэгэн насандаа хүртэж болох оюун санааны их өв хөрөнгө, *хамаг жаргалан гарахын орон, гашуун зовлонг сэргээгч*⁹⁸ эм гэж үзэж байсан учир бурханы зарлиг сургаалыг төвөд хэлнээс орчуулах үйлийг ихэд хүндлэн дээдэлж, чин үнэн сэтгэлээсээ хандаж байжээ. Тиймээс ч *орчуулагч хэлмэрч нүгүүд ...ямагт бурханы шашныг дотнолон барихыг сэтгэлдээ сэтгэж, ашиг хийгээд алдрыг хүсэх, алагчлах сэтгэлийг тэвчиж, шударга оюунаар үг утгасын хувийг сайтар шинжлээд ...утга лугаа үл харшилдуулан сайтар орчуулваас өөр бусдын үндсэнд олон сайн чуулганыг арвитган чадах бөгөөд бурханы шашинд тус үйлдсэн болохын тул үлэшгүй буяны цогцыг олох болмуй за*⁹⁹ хэмээн “Мэргэд гарахын орон” толь бичигт бичсэн байна. Бурханы зарлиг сургаалыг орчуулсан буянаар хүн зон элдэв өвчин болон айх аюулгүй, сэтгэл санаа амар амгалан, цаг зуурын зуд турхангүй, хур бороо элбэг, тариа төмс арвин, мал сүрэг өсөж үржин, төр төвшин байж, шашин ном дэлгэрэх, нэн ялангуяа бурханы зам мөрөөр замнаж, бурханы хутгийг олохыг хүсэн ерөөсөн үгийг орчуулгынхаа төгсгөлийн шүлэгт бичиж байжээ¹⁰⁰. Орчуулгын ажил ийнхүү буянтай ариун үйл учраас монгол гүүш нар алдаа мадагтай хөрвүүлвэл шашин номын утгыг гуйвуулсан гэм нүгэл болохыг ухаарч, бурханы ариун сургаалыг сүсэгтэн олон түмэнд эндүү ташаа алдаа мадагтай хүргэхээс болгоомжилж байв. Тиймээс манай дуун хөрвүүлэгчид бурханы сургаалыг зөв ухаарч ойлгохыг ихэд чухалчилж, олон арван тайлбар, сурвалж бичгүүдийг шүүрдэн үзэж байв. Их дуун хөрвүүлэгч Зая бандид Намхайжамц *эрхэт бурханы зарлиг онохуйя маш бэрх хийгээд... эрэн онохуй өөрийн оюун маш мохдог тул... үүнийг орчуулахуйя аюул маш их төрмүй*¹⁰¹ хэмээн бурханы шашны гүн сургаалын утга агуулгыг ухаж ойлгох амар хялбар бус, аливаа орчуулгын ажил маш их хичээл зүтгэл, зориг тэвчээрийг шаарддаг, орчуулагчийн мэдлэг дутах явдал бишгүй тааралдаж байсан тухай өгүүлсэн байна. Түүнчлэн уншигчдадаа хандаж

*Нигүүлсэхүй их буян садан та бээр
Нягтлан шинжилж анхаарахын цагт
Нигүүлсэн айлдаж буруу хазгай болсныг
Нэгэнтээ засаж айлдаад хүлцэн соёрх*¹⁰²

хэмээн засан залруулахыг хүсэн гуйж бичсэн байна. Энэ нь орчуулгадаа эргэлзэж, итгэл муутай байсан бус, харин эндэж алдсан байж болзошгүй хэмээн уншигчдаа хүндэтгэн хүлцэл өчсөн хэрэг юм. Хэдийгээр алдаа мадаггүй орчуулахыг дуун хөрвүүлэгчид хичээж байсан боловч үг үсгийн болон утгын мадагтай эхийг ашигласан, мэдлэг туршлага дутсан зэргээс алдаа гарч байжээ. Тиймээс үнэн зөв

⁹⁸ “Банзрагч” судрын хэд хэдэн гар бичмэл эхэд ингэж бичжээ. Энэ үг зовлонг арилгах гэсэн утгаар орсон байна.

⁹⁹ Д.Бүрнээ, Д.Энхтөр, *Уламжлалт монгол орчуулгын судлалд*, УБ., 2013, 300-р тал.

¹⁰⁰ Д.Бүрнээ, *Орчуулагчийн ёс зүйг судлах асуудалд*, - Мэргэжлийн ёс асуудал, УБ., 88-р тал.

¹⁰¹ Г.Билгүүдэй нар, *Ц.Дамдинсүрэнгийн гэр музейн монгол ном судрын бүртгэл*, УБ., 2018.

¹⁰² Г.Билгүүдэй нар, *Ц.Дамдинсүрэнгийн гэр музейн монгол ном судрын бүртгэл*, УБ., 2018, 180-р тал

орчуулахын тулд төвөд эхийн гүн нарийн утгыг эндүүрэлгүй буулгах зорилгоор аль болох их судалгаа хийж байв. Энэ тухай Алтангэрэл увш бичсэн нь үүнээс урьд бүхий бусад мэргэдийн орчуулга энэ монгол газраа дэлгэрч олон буй бөгөөс бээр эсрэг тэсрэг үг утгас нь зохилдох бусын тулд түүтгэрэл үгүй сүсэгт Баясгалан нэрт тидши тэмдэгтэйе орчуул хэмээн бас бас дуртгасандтэд мэргэдийн орчуулгыг буруушааж бурчиж засваас л тэрслэх найдангуйгаар үйлдсэн хэмээгдэх бүхийн тулд тэл хэлт Алтангэрэл увш төвөдийн олон эх бичгүүдийг тохиолдуулж төсөөлж мэдсэн чинээгээр монголын аялгууд засаж орчуулж оршуулбай¹⁰³, асар олон эх төвөд бичгүүдийг нийлүүлэн тохиолдуулж, аялгуу утгасыг алжаас болгохуй /алдаа эндэл болуузай Д.Б/ хэмээн ариутган төгсгөж Алтангэрэл увш аль мэдсэний чинээгээр асар хичээж монголын хэлэнд орчуулж оршуулбай”¹⁰⁴ гэжээ. Алтангэрэл увш эн тэргүүн өмнөх үеийн орчуулгын алдаа мэдгийг засахыг өөрийн үүрэг гэж үзсэн, нөгөөтэйгүүр, бусад хүмүүс дуртган хэлж сануулсныг хүлээн авсан байна. Тэр бээр бусдын орчуулгыг дур мэдэн засахыг буруу гэж үзсэн учир олон эх сурвалжийг үзэж нягталж судалсны дараа сая засан залруулсан болохыг энэхүү төгсгөлийн үгээс бид мэдэж авч байна. Төвөд хэлнээс орчуулсан ном судрын дотор алдаа мадаг цөөнгүй гарч байсан учир түүнийг ариутган шүүхийг ихэд анхаарч байсан талаар судрын орчуулгын төгсгөлийн үгд тодорхой тэмдэглэжээ.

Орчуулгын түүхээс үзвэл орчуулгыг алдаа мэдгээс нь үүдэж бус, харин тодорхой зорилгоор бас засан найруулж байсан байна. “Алтан эрих” нэрт түүхэн сурвалж бичигт тэмдэглэснээр 1628-1629 онд төвөд Ганжуурын мянга гаруй зохиолын монгол орчуулгыг бард бүтээж хэвлэх зорилгоор тусгайлан хянан тохиолдуулжээ. Ийнхүү хянан нягтлахдаа зарим ном судрын хуучин орчуулгыг хэл найруулгын талаас нь их бага ямар нэгэн хэмжээгээр засан найруулжээ. Энэ нь монгол Ганжуурын эмхтгэлд оруулахаар сонгосон орчуулгууд төвөд Ганжуурын өөр өөр бар болон бусад олон зүйлийн төвөд бар хэвлэл, гар бичмэл тэргүүтнийг эхэд барьж хийсэн орчуулга байсан учир хэл найруулгын талаар төвөд Ганжуурын хятад шунхан барын эхээс ялгаа зөрөөтэй болсонтой холбоотой. Өөрөөр хэлбэл, төвөд эх судартай дүйх ёстой гэдэг үзэл баримтлалыг мөрдөж, төвөд Ганжуурын хятад шунхан барын эхийн дагуу хуучны орчуулгуудыг хянан зассан байна. Ийнхүү зассан жишээг монгол Ганжуурын 90-р ботид орсон “Шулуун онолт” буюу олны дунд “Үлгэрийн далай” хэмээн алдаршсан судрын жишээн дээр авч үзье. Тус судрыг Хөх хотын алдарт орчуулагч Ширээт гүүш 17-р зуунд орчуулсан билээ. Уг орчуулга төвөд Ганжуурын доторх “Занлун” (mdzangs blun) судартай утга агуулгаараа дүйх боловч бөлгийн тоо болон хэл найруулгын талаас зөрөөтэй. Тиймээс Ширээт гүүшийн орчуулгыг монгол Ганжуурт оруулж эмхтгэхийн тулд хятад шунхан барын төвөд Ганжуурт бүхий “Занлун” судартай тулгаж, түүний хэл найруулгын дагуу зассан байна. Ийнхүү засахдаа Ширээт гүүшийн орчуулгад байхгүй үг, өгүүлбэрийг нэмэн оруулжээ. Тухайлбал:

¹⁰³Г.Билгүүдэй нар, Ц.Дамдинсүрэнгийн гэр музейн монгол ном судрын бүртгэл, УБ., 2018, 59-р тал.

¹⁰⁴Г.Билгүүдэй нар, Ц.Дамдинсүрэнгийн гэр музейн монгол ном судрын бүртгэл, УБ., 2018, 39-р тал.

Хятад шунхан барын төвөд Ганжуур дахь “Занлун”	1714, 1728 онд хэвлэгдсэн “Үлгэрийн далай”	Монгол шунхан Ганжуур дахь “Шулуун онолт” судар
Bya gag gis nor bu med [med] par dge slong gis mthong yang tshul khrimbs bsrung ba'i phyir sdug bsngal myong bar byed kyi gtam mi zer ro	----- ---	Taqiy-a sibayun čindamani -yi jalıyiqui dur ayay-a tekimlig üjebesü ber šayšabad saqıqu-yin tula jobalang-i üjebesü ber üges-i ese ügülebei

Монгол шунхан Ганжуурт Ширээт гүүшийн орчуулгад байхгүй үг өгүүлбэрийг нэмэн оруулахаас гадна зарим засвар хийжээ. Тухайлбал:

Хятад шунхан барын төвөд Ганжуур дахь “Занлун”	1714 болон 1728 онд хэвлэгдсэн монгол “Үлгэрийн далай”	Монгол шунхан Ганжуур дахь “Шулуун онолт” судар
Bdag chos tshol ba 'di yang sangs rgyas su <u>bsgrub pa'i</u> phyir te	Minü nom erigsen ene ber burqan-u qutuı-yi <u>olyayulqu yin</u> tulada buyu	Minü nom erigsen ene ber burqan-u qutuı-I <u>bütügekü-</u> yin tulada buyu
dong de yang Me me tog gi <u>rdzing bur gyur</u> te	Tere γau ber čečeglig tü <u>qarsi</u> bolbai	Tere γau ber čečeglig-ün <u>čögerembolbai</u>
Sdig pa grogs po la bsten na ni <u>sdig pa'i chos skye bar 'gyur</u> te	Nigül tü nöküd-tür sitübesü <u>nigül ber nemeyü</u>	Nigül tü nökür-i sitübesü <u>kilinče tü nom törüjü</u>

Дээрхи хүснэгтээс харвал, Ширээт гүүшийн орчуулгыг хэл найруулгын хувьд өөрчилсөн болох нь харагдана. Үүнд “Үлгэрийн далай” сударт “олгуулахын тулд” гэснийг монгол шунхан Ганжуурт “бүтээхийн тулд”, “цэцэглэгт харш” гэснийг “цэцэглэгт цөөрөм”, “нүгэл бээр нэмюү” гэснийг “хилинцэт ном төрж” гэх зэрэг хятад барын төвөд судрыг баримталж зассан нь харагдана. Түүнчлэн зарим нэр томъёо, оноосон нэрийн орчуулгыг хэрхэн зассаныг ажиглавал “гэцэл” гэсэн үгийг “Үлгэрийн далай” сударт “ёст буянт тойн”, харин монгол шунхан Ганжуурт “гэцэл” гэсэн төвөд үгээр засжээ. Түүнчлэн “Үлгэрийн далай”-д “хатан хараа” гэсэн шувууны нэрийг монгол шунхан Ганжуурын эхэд “ван шувуу” гэж төвөд үгийг хуулбарлан буулгажээ. “Гэлэнма” гэсэн үгийг “шамнанц” гэж санскритаар сэргээн орчуулсан, харин монгол шунхан Ганжуурт “аяга тэхимлиг” гэсэн уйгар гаралтай үгээр буулгажээ. Зааны хүйсийг зааж “үнээ заан” гэж Ширээт гүүшийн орчуулсаыг монгол шунхан Ганжуурт “заан” гэсэн үгийг хасчээ. Түүнчлэн “Үлгэрийн далай” сударт олонтоо тааралдах “Итгэл үгүй идээн өглөгт” (тө. mgon med zas 'dzin) хэмээх нэгэн гэрийн эзний нэрийг

монгол шунхан Ганжуурын эхэд “Итгэл үгээгүүнээ идээн өглөгт” гэж засан найруулжээ. Сүүлийн жишээний тухайд оновчтой засвар болсон гэж бодож байна. Учир нь Ширээт гүүш зовож зүдэрсэн ард олонд өглөг өгдөг, лам хувраг нарыг хоол хүнс, орон гэрээр хангаж ивээн тэтгэгдээрээ алдаршсан гэрийн эзний нэрийг “итгэл үгүй” (mgon med) гэж төвөд эхийг хуулбарлан буулгасан нь зөв боловч уншигчдад “итгэл, найдваргүй” нэгэн мэт сэтгэгдэл төрүүлж болзошгүй байсан учир “итгэл үгээгүүнээ” буюу итгэл найдваргүй болж цөхөрсөн хүнд гэсэн санааг өгөх оршихын тийн ялгалаар найруулсан нь оносон гэж бодож байна. Ширээт гүүшийн орчуулгад огт байхгүй үг өгүүлбэрийг нэмж, хэл найруулгыг өөрчилсөн учраас монгол шунхан Ганжуурын “Үлгэрийн далай” судрын төгсгөлд орчуулагчийн нэрийг хассан бололтой. Ийнхүү монгол Ганжуурыг хэвлэхийн тулд эртний орчуулгуудыг засан найруулсан явдал бол хятад шунхан барын эхийг барьж орчуулгуудыг журамлах гэсэн зорилготой холбоотой. Нөгөөтэйгүүр, ингэж төвөд эхийг барьж засдаг энэ уламжлалыг хожуу үеийн буюу 19 зууны дуун хөрвүүлэгчид ч бас баримталж байсныг буриад орчуулагчдын бүтээлээс харж болох байна. Тухайлбал, Данаагийн Галсанжамба “Субашид”-ийн Мэргэн гэгээний орчуулгыг, Номтын Ринчен буюу Лувсанринчен Цахар гэвш Лувсанчүлтэмийн орчуулгыг засан найруулсныг дурдаж болно. Саж бандид Гунгаажалцангийн зохиосон иргэний яруу найргийн зохиол болох “Субашид”-ийн эрт болон хожуу үеийн олон орчуулга дотроос Цахар гэвш Лувсанчүлтэмийн орчуулга онцгой ялгардаг. Үг утгыг төдийгүй уран сайхныг төвөд эхийн найруулгад уягдалгүй чөлөөтэй буулгасан явдал уг орчуулгыг бүтээлч орчуулга болгож байна. Ийм орчуулгыг засан найруулах шаардлагагүй боловч Номтын Ринчен өөрчлөн найруулсан нь өмнөх үеийн орчуулагчдын төвөд эхийн хэлбэрт ойртуулж засаж байсан уламжлалаас үүдэлтэй. Төвөд эх судрын үг утгыг ургуулан бодож, нэмэн дэлгэрүүлж, баяжуулсан Цахар гэвшийн орчуулгыг Номтын Ринчен төвөд эхээс холдсон гэж үзсэн бололтой. Тиймээс тэр бээр төвөд эхэд байхгүй үг хэллэг, утга санааг хасаж, Цахар гэвшийн орчуулгыг засан найруулсан байна. Тухайлбал, “Субашид”-ийн 15-р бадагт 7 үеэр тэнцүүлж

blo gros ldan pa gnyis bgos na
blo gros legs pa gzhan 'byung srid
yung ba dang ni tsha la las
kha dog gzhan zhig skye bar 'gyur

гэж шүлгэлснийг Цахар гэвш:

Шударга сайн ухаантан хоёр хүн нийлэн хэлэлцвэл
Шалгадаг нэгэн сайн бодлого гарах болно за
Шар улаан хоёр зүйл будгийг нийлүүлэн зуурвал
Шинэ өөр нэгэн өнгө гарахтай адил

гэж орчуулсан бол Номтын Ринчен

Шударга сайн ухаант хоёр хүн нийлэн хэлэлцвээс
Шалгадаг нэгэн бодлогот сайн оюун гарам
Шар юнваа лугаа тунсааг нийлүүлэн зуурваас

*Шинэ өөр нэгэн сайхан өнгө гарам*¹⁰⁵

гэж засан найруулсан байна. Энд гол зассан зүйл бол төвөд эхийн “yung ba” ба “tsha la” хэмээх хоёр үг болно. Энэ хоёр үгийг зарим орчуулгад төвөдөөр нь зээлж “юнва”, “цала” (Мэргэн гэгээн), “цала”-г орчуулж “тунсаа” (Зая бандид) гэж орчуулсан ч тааралдана. Төвөд-Монгол тольд “цала”, “юнва” хэмээх хоёр үгийг “цала”, “юнва” гэж төвөдөөр буулгахаас гадна “цала”-г “тунсаа”, “юнва”-г “шар гаа” гэж орчуулжээ. О. Сүхбаатар “Монгол хэлний харь үгийн толь”-доо “тунсаа” гэдэг үгийг “цагаан саарал, шаравтар ногоовтор өнгөтэй эрдэс, юм гагнахад хэрэглэнэ” гэж тайлбарлажээ. Тэгвэл “Bod yig tshig gter rgya mtsho”-д (Төвөд үгийн сангийн далай) “юнва”-г “sga ser” буюу “шар гаа”, “цала”-г “нэг зүйл давс бөгөөд цайвар хөх өнгөтэй, гадна тал нь цагаан цайвар, эмийн ургамалд ордог, давсны амттай, шингээлт тэгш, шарх болон муу цусыг хатаадаг, усан хаван засдаг” гэжээ. Эндээс бид “цала” бол цагаан цайвар, хөх саарал, шар ногоон зэрэг өнгөтэй гэж ойлгож байна. Цахар гэвш эл хоёр үгийг “шар улаан хоёр зүйл будаг” гэж орчуулсныг Номтын Ринчен юнваагийн өнгө нь тодорхой шар учраас “шар юнва” гээд харин “цала” буюу “тунсаа”-г өнгөөр нь төлөөлүүлэлгүй монгол нэрээр нь “тунсаа” гэж авсан байна. Мөн зарим нэг дагавар нөхцөлийг өөрчилж, үг ч нэмжээ. Тэгвэл Цахар гэвш ямар учраас эл хоёр үгийг “шар, улаан будаг” гэж авсан бэ? Энэ бадгийн гол санаа бол хоёр ухаантай хүн ханилвал үлэмж илүү ухаан гарна гэсэн санаа бөгөөд түүнийгээ хоёр зүйлийн бодисыг нийлүүлбэл өөр өнгө гарна гэсэнтэй жишин адилтгасан хэрэг юм. Үнэхээр улаан болон шар хоёр өнгө бол маш сайхан найрч энэ хоёр өнгийн дундаас улбар шар өнгө гарах нь тодорхой. Гэтэл төвөд эхийг дагуулан “юнва болон тунсаа” хоёроос өөр өнгө гарна гэж буулгах нь төвөд эхийг үнэн зөв буулгаж буй хэрэг боловч уншигчдад нэн ялангуяа энэ хоёр бодисыг мэдэхгүй хүнд бол шууд буухгүй. Тиймээс Цахар гэвш хоёр ухаантай хүн нийлэн хэлэлцэхийг “шар, улаан хоёр зүйл будгийг нийлүүлэн зуурвал нэгэн зүйл өөр нэг өнгө гарахтай” жишин адилтгажээ. Өөрөөр хэлбэл, Цахар гэвш шүлгийн утга санааг амар хялбар ойлгуулахыг зорьсон хэрэг. Нөгөөтэйгүүр, “цала” буюу тунсаагийн өнгө цайвар боловч яг тодорхой биш, цайвар хөх бас шаравтар, ногоовтор ч байж болох учраас энэ хоёр өнгийг нийлүүлэхэд өөр өнгө гарна гэж төвөд эхийг дагуулж буулгах нь оновчтой биш гэж үзсэн байж болох талтай. Харин Номтын Ринчен төвөд эхэд гарч буй үг хэллэгийг өөрчлөхгүй, яг байгаагаар нь уншигчдад хүргэхийг чухалчилжээ. Өөрөөр хэлбэл тэдгээр бодисын өнгө хэр найрч шинэ өнгө гарахыг бодис зүйн талаас чухалчилсангүй, харин төвөд эхэд бичсэнийг л гол болгожээ. Үүнийг бас нөгөөтэйгүүр, Цахар гэвш харийн утга соёлыг өөрийн соёлд идээшүүлэхийг зорьсон хандлагатай, харин Номтын Ринчен төвөд утга зохиолын онцлог бүхий үг хэллэгийг хэвээр нь буулгаж харийн соёлын онцлогийг хадгалах ёстой гэсэн ялгаа зөрөөтэй үзэл баримталж байснаар тайлбарлаж болох юм.

¹⁰⁵ Д.Бүрнээ, Д.Энхтөр, Уламжлалт монгол орчуулгын судлалд, УБ., 2013.

Дүгнэлт

1. Монголчууд төвөд ном судрын олон бар хэвлэлийг ариутган шүүж байсан нь эх судрыг зөв уншиж ухаарах, судалж орчуулахад чухал алхам болж байжээ.
2. Эх судрын утга агуулгыг эндүү ташаа буулгахгүйн тулд бусад холбогдох олон ном судрыг задлан шинжлэх нь зүйтэй гэж монгол гүүш нар үзэж байв.
3. Хуучин орчуулгын төвөд эх судар нэгэнт үрэгдэж гээдсэн буюу олдохгүй болсон тохиолдолд түүнийг тухайн цаг үед жишиг болгосон тодорхой нэг төвөд эх судартай зэрэгцүүлэн тулгаж, журамлах зорилгоор засан найруулж байсныг монгол Ганжуурын 90-р ботид бүхий “Шулуун онолт” буюу “Үлгэрийн далай” судраас харж болох юм.
4. Энэ уламжлалыг 19 дүгээр зууны дуун хөрвүүлэгчид үргэлжлүүлж, төвөд хэлээрх иргэний яруу найргийн зохиолын чөлөөт утгачилсан орчуулгыг хянах засахдаа ч хэрэглэж байжээ. Энэ нь төвөд эх судар олдохгүй болсонтой холбоогүй, харин бурханы шашны ном судрыг орчуулахдаа эхээс хазайлгахгүй, эхийн утга болон хэлбэрийг ариунаар буулгах ёстой гэсэн үзэл баримтлалыг иргэний ном судрыг орчуулахад ч баримтлах учиртай гэж үзэж байсантай холбоотой. Өөрөөр хэлбэл, төвөд хэл соёлын нөлөө хүчтэй байсныг харуулах нэгэн баримт болох юм. Нөгөөтэйгүүр, төвөд хэлнээс орчуулсан ном судрыг тухайн үеийн тодорхой үзэл баримтлалд нийцүүлэн хэрхэн хянан тохиолдуулж байсан арга туршлагыг харуулж байна.

Резюме

Монгольские переводчики уделяли большое внимание редактированию тибетского подлинника буддийской литературы. Ярким примером тому служит редакция монголами Нартанского издания тибетского Канжура. Оно сыграло важную роль в установлении безошибочного текста, в правильном понимании и переводе тибетской литературы. При редакции монгольского Канжура основным тибетским подлинником был выбран тибетский Канжур пекинского издания. Из истории монгольского перевода мы можем заметить, что эта традиция была унаследована и при переводе литературы светского характера.

Ном зүй

1. Г.Билгүүдэй нар, Ц.Дамдинсүрэнгийн гэр музейн монгол ном судрын бүртгэл, УБ., 2018.
2. Д.Бүрнээ, Д.Энхтөр, Уламжлалт монгол орчуулгын судлалд, УБ., 2013.
3. Д.Бүрнээ, Монголчуудын төвөд хэлнээс орчуулсан зохиолын тойм, Орчуулгазүй №5, УБ., 2016.
4. Д.Бүрнээ, Монгол Ганжуурыг ариутган зассан тухай асуудалд, Монгол судлал, ЭШБ, боть XXXVII (392), УБ, 2013, 153-157-р тал.
5. Д.Бүрнээ, Орчуулагчийн ёс зүйг судлах асуудалд, Мэргэжлийн ёс зүйн асуудал, УБ., 2018, 86-93-р тал.